



ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН
ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ САЛБАР ЗӨВЛӨЛИЙН
ТОГТООЛ

2021 оны 08 сарын 22 өдөр

Дугаар 01

Мандалговь

Б.Индраг Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний
газрын хяналт, шинжилгээ, үнэлгээ хариуцсан
ахлах мэргэжилтний албан тушаалд
нэр дэвшүүлэх тухай


Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 14 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн албаны тусгай шалгалт өгөх болзол, журам”-ын 7 дугаар зүйлийн 7.2 дахь заалт, Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 59 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн ажиллах журам”-ын 3 дугаар зүйлийн 3.5.4 дэх заалт, Төрийн албаны зөвлөлийн тус аймаг дахь салбар зөвлөлийн 2021 оны 7 дугаар хуралдааны шийдвэрийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

Нэг. Аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын Хяналт шинжилгээ, үнэлгээ хариуцсан ахлах мэргэжилтний албан тушаалд томилогдох ажилтны сонгон шалгаруулалтад Баясгалангийн Индра 54.6 оноогоор тэнцсэн тул тухайн албан тушаалд нэр дэвшүүлсүгэй.

Хоёр Ажлын байрны шаардлагыг хангаж байгаа Б.Индрагийн холбогдох материалыг томилох эрх бүхий албан тушаалтанд хүргүүлэхийг салбар зөвлөлийн ажлын албанд даалгасугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ Ш.ТӨРБАТ





**Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын хяналт, шинжилгээ,
үнэлгээ хариуцсан ахлах мэргэжилтний албан тушаалд
нэр дэвшүүлсэн Б.Индрагийн тухай дүгнэлт**

1. Б.Индра нь 1997 онд Дундговь аймгийн Сайнцагаан суманд төрсөн. 25 настай, эмэгтэй
2. Боловсролын байдал: 2014-2018 онд Шинжлэх ухаан техникийн их сургуулийг нийгмийн ажилтан мэргэжлээр бакалаврын зэрэгтэй суралцаж төгссөн.
3. Туршлага: 2018-2020 онд Хөдөлмөр халамжийн үйлчилгээний газарт хүнс тэжээлийн дэмжлэг туслалцаа хариуцсан мэргэжилтэн, 2020 оноос тус газарт хяналт шинжилгээ үнэлгээ хариуцсан ахлах мэргэжилтний албан үүргийг түр орлон гүйцэтгэгчээр ажиллаж байна.
4. Б.Индра нь тухайн ажлын байрны ерөнхий болон тусгай шаардлагыг хангаж байгаа болон тухайн албан тушаалын сонгон шалгаруулалтад тэнцсэн зэргийг харгалзан Хөдөлмөр халамжийн үйлчилгээний газрын хяналт шинжилгээ үнэлгээ хариуцсан ахлах мэргэжилтний албан тушаалд томилуулах санал, дүгнэлтийг гаргаж байна.

ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН САЛБАР ЗӨВЛӨЛ